# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 11 сарын 03 өдөр Дугаар 571 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.4.4, 6.6 дахь заалт, 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дорнод аймаг дахь Ус цаг уур, орчны шинжилгээний газрын хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй нийт 29,331,000.00 (хорин есөн сая гурван зуун гучин нэгэн мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 2 ширхэг автомашиныг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Дорнод аймаг дахь Ус цаг уур, орчны шинжилгээний газрын дарга М.Алтаннавчид дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг хууль тогтоомж, журмын дагуу Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Акталж, данснаас хассан автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолт, дээрх арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 11 дугаар сарын 03-ны өдрийн
571 дугаар тогтоолын хавсралт

**ДОРНОД АЙМАГ ДАХЬ УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТЛАЖ ДАНСНААС ХАСАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

| Д/д | Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар | Үйлдвэрлэсэн /ашиглалтад/ орсон он | Нийт гүйлт /км/ | Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/ |
|---|---|---|---|---|
| 1 | Исүзү бигхорн, суудлын, 91-85 ДОА, арлын дугаар UBS 73 GW 7200202 | 1999/1999 | 160000 | 15,900,000.00 |
| 2 | УАЗ-469 Суудлын, 69-80 ДОА, /модель 31512, хөдөлгүүрийн багтаамж В-2445, хөдөлгүүрийн №60013927, арал: 70563702 | 2007/2007 | 160000 | 13,431,000.00 |
| **Нийт дүн** | | | | **29,331,000.00** **(хорин есөн сая гурван зуун гучин нэгэн мянга)** |